БАТЛАВ
"ЭБЦТС" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ В.АДЪЯА

БУЛГАНЫ ЗАСГИЙН ГАЗАР ЭРДЭСТ ТҮЛШЭХ ХЭЛТЭС ТӨХК ОРХОН АЙМАГ

ОРХОН АЙМГИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ (6 КВ-ЫН ТОЙРОГ СХЕМ ҮҮСГЭХ) ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022.02.14 № 01/2022 ОРХОН АЙМАГ

1	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах үндэслэл	• "ЭБЦТС" ТӨХК-ийн 2022 оны Техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан.
2	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	• Бэлтгэл ажил • ТЭЗҮ • Ажлын зураг төсөв
3	Байршил	• Орхон аймаг Баян-Өндөр сум
4	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол улсын хуулиуд:</u> • Эрчим хүчний тухай хууль • Барилгын тухай хууль • Барилгын норм ба дүрэм • Бусад холбогдох хууль тогтоомжууд <u>Норм, норматив</u>ууд: • MNS 5834:2008 стандарт • БД 43-102-07 дүрэм • БД 43-101-03 дүрэм
5	Зориулалт, хүчин чадал	• ЦЭХ-ийн найдвартай байдал, өсөн нэмэгдэх хэрэглээ зэргийг тооцож Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэсвгэрт 6/0.4 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж шинээр барих мөн эдгээр ХХБ-ууд нь өөр хоорондоо болон шинээр баригдах 35/6 кВ-ын дэд станцууд, одоо байгаа 35/6 кВ-ын дэд станцуудтай 6 кВ-ын хос кабель шугамаар холбогдсон байхаар ТЭЗҮ, ажлын зураг төсвийг гүйцэтгэх.
6	Одоогийн байдал	• Хурдацтай өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангахад хүндрэлтэй, дэд станц болон ЦДАШ-ууд хэт ачаалалд орох эрсдэл өндөр. • Оргил ачаалал болон болзошгүй эрсдлийн үед дэд станцууд нь өөр хоорондоо сэлгэж ажиллах, цахилгаан ачааллыг шилжүүлэх зохион байгуулалт хийхэд хүндрэлтэй, тэдгээрийг холбосон шугам, хуваарилах байгууламж дутмаг байгаа нь хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангах бололцоог бууруулж байдаг.
7	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
8	Төслийн захиалагч	"ЭБЦТС" ТӨХК

9	Төсөл боловсруулах байгууллага	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах байгууллага нь тухайн чиглэлийн тусгай зөвшөөрөлтэй, ажлын туршлагатай байна.
10	ТЭЗҮ, ажлын зураг төслийн бүрдэл	<u>ТЭЗҮ, зураг төсөлд тавигдах шаардлага:</u> • ТЭЗҮ, Зураг төслийн баримт бичиг 3 хувь. Эх хувиас гадна 1 хувийг CD-ний хамт захиалагчид өгч , үлдсэн нэг хувийг Орхон аймгийн архивын газарт өгнө. • ТЭЗҮ-д техник-технологи, эдийн засаг, хууль эрх зүй, үйл ажиллагаа, цаг хугацааны хувьд судалгаа хийсэн байна. • Ажлын зурагт шинээр баригдах 6/0.4 кВ-ын хуваарилах байгууламжийн иж бүрдэл, хийц, цахилгаан дамжуулах кабель шугам болон бусад байгууллагын шугам сүлжээний зохицол, хоорондын зай хэмжээг тодорхой тусгаж, ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай. Мөн Орхон аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан байна.
11	Төсөл боловсруулах үе шат	• Бодит байдлын талаарх судалгааг хийх /одоогийн нөхцөл байдал, ачааллын судалгаа г.м/ • Ашиглагч байгууллагатай зөвшилцөж ажлын зураг төсөв гүйцэтгэх. • Ажлын зураг төсөвт магадлал хийлгэх. • Зураг төслийн дагуу угсралтын ажилд шаардагдах хяналтын төсвийг гаргах. • Угсралтын ажлын явцад зохиогчын хяналт тавих.
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	• Төсвийг ESTIMAOTR-PRO программ болон түүнтэй ижил цалинг дундаж зэргээр тооцдог зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно.
13	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	Зураг төсөлд холбогдох БНбД-үүд, техникийн нөхцөл шаардлагын хүрээнд инженерийн шугам сүлжээнд нэвтэрч буй шинэ /дэвшилтэд/ технологийг ашиглахаар тусгаж өгөх.
14	Ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад ашиглах материал	Орхон аймгийн цахилгаан хангамжийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа. Инжерийн шугам сүлжээний мэдээлэл бүхий 1:1000 масштабтай байр зүйн зураг. Орхон аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө.
15	Төслийн иж бүрдэл	Орхон аймгийн цахилгаан хангамжийн 6 кВ-ын тойрог схемийн иж бүрэн ТЭЗҮ, ажлын зураг төсөв /магадлал хийгдсэн/, хяналтын төсөв, зохиогчийн хяналт.
16	Онцгой нөхцөл (төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд)	• 6/0.4 кВ-ын хуваарилах байгууламжийн байршлыг нарийвчлан тогтоох. (Орхон аймгийн ГХБХБГ болон "ЭБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх) • Тогтсон байршилд инженер-геологийн судалгаа хийх. • Хуваарилах байгууламж нь орчин үеийн дэвшилтэд технологи, техникийн шийдлийг агуулсан байх ба техникийн нөхцлийн шаардлагыг хангадаг байх. • Хуваарилах байгууламжийн 6 кВ, 0.4 кВ-ын үүрний марк, тоо хэмжээг ашиглагч байгууллагатай зөвшилцөх.

		• Цахилгаан дамжуулах кабель шугамын тоо, марк, хөндлөн огтлолыг тооцоогоор сонгох, уртыг инженерийн шугам сүлжээний зөрлөгийг нарийвчлан тооцсоны үндсэн дээр бодитоор гаргах. • Цахилгаан дамжуулах кабель шугамын холболтын болон төсгөлийн муфтын марк, тоо хэмжээг ашиглагч байгууллагатай зөвшилцөх. • Хөрсний зэргийг нарийвчлан тогтоож газар шорооны ажлын эзэлхүүнийг бодитоор гаргах. • Цахилгаан дамжуулах кабель шугамыг хамгаалах арга хэмжээг нарийн тооцох, кабелийн тэмдэглэгээг байрлуулах цэгийг ажлын зурагт тусгах. • Төсөв хийх үед ажлын дараалыг зөв тооцож анхаарах. • Зургийн нэр төсвийн нэр адилхан байхад анхаарах.

ХЯНАСАН:

ТҮА ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭЦОГТ

ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХСҮЛД

БОЛОВСРУУЛСАН:

ЗУРГИЙН ИНЖЕНЕР Г.МӨНХТУЛГА